

I-V ангийн зохион найруулж, дуурайн найруулж бичих чадварын агуулгын залгамж холбоо

| Анги | 1-р анги | 2-р анги | 3-р анги | 4-р анги | 5-р анги |
|---|---|--|---|--|--|
| БИЧИХ ЧАДВАР | | | | | |
| Зохион найруулж, дуурайн найруулж бичих | 1.2.в. Зураг, бүдүүвчид тохирсон 3-4 үгтэй өгүүлбэр зохиож бичих | | | 4.2д. Үйл явдлыг өрнүүлэн, утгын уялдаа холбоотой богино өгүүлэг зохиох | 5.2в. Эхийн үйл явдлын орчныг өөрчлөн богино өгүүлэг хүүрнэн зохион бичих |
| Зохион найруулж, дуурайн найруулж бичих | 1.2.г. Багшийн хэлсэн 2-4 үгээс бүтсэн өгүүлбэрийг сонсож, цээжээр бичих | 2.2.д Багшийн хэлсэн 5-6 өгүүлбэрийг сонсож, цээжээр бичих | | | 5.2.г.Зохиолын санааг нэгтгэн дүгнэн, товчилж бичих |
| | | | 3.2д. Баярласан сэтгэлээ илэрхийлж, бүтцийн дагуу талархсан утгатай захидал бичих | 4.2е. Өгсөн бүтцийн дагуу утгын уялдаа холбоотой бахархсан утгатай захидал бичих | 5.2.д. Бусдын үзэл бодлыг дэмжиж, эсвэл эсэргүүцсэн утгатай захидал бичих |
| | | 2.2.е. Өгсөн бүтцийн дагуу мэндчилгээ бичих | 3.2е. Хүсэл мөрөөдөл, зорилготойгоо нийцүүлж төлөвлөгөө зохион бичих | 4.2ж. Бусдыг сайн сайхан зүйлд уриалж бүтцийн дагуу уриалга бичих | " 5.2.е. Өөртөө тохиолдсон явдлаа сэтгэгдэл, мэдрэмжээр илэрхийлэн өдрийн тэмдэглэл бичих" |
| | | 2.2.ж Өгсөн бүтцийн дагуу болсон явдлаа ойлгомжтой бичих | 3.2ж. Өгсөн зааврын дагуу тоочин жагсааж бичих | 4.2з. Өгсөн асуултын хүрээнд сонины товч мэдээ бичих | 5.2.ж Чухал, шинэ үйл явдлыг баримтаар нотлон, бүтцийн дагуу мэдээ бичих |
| | | 2.2.з Өгсөн бүтэц зааврын дагуу баярлаж талархсанаа илэрхийлсэн талархал бичих | | 4.2и. Хүндэтгэлийн үг хэрэглэн, бүтцийн дагуу урилга бичих | 5.2з. Бусдын анхаарлыг таттал яггаж бичих |
| | 1.2.д. Өгсөн загвар, асуулт, цуврал зургийн дагуу 3-4 өгүүлбэр зохиож бичих | 2.2.и. Сэдэвт болон цуврал зургийг хараад утгын холбоотой 4-5 өгүүлбэр бүхий эх зохиох | 3.2з. Өгсөн сэдэв, бүтцийн дагуу үлгэр зохиож бичих | 4.2к. Бүтцийн дагуу үлгэр зохиохдоо баатрын гадаад дүр байдлыг дүрслэн бичих | 5.2.и Жүжигт баатруудын харилцан яриаг нэмэн бичих |
| | | 2.2.к"Ертөнцийн гурав"-ын хэлбэрийг дуурайн зохиож бичих | 3.2и. Шүлэг, "ертөнцийн гурав"-ын хэлбэрийг дуурайн зохиож бичих | 4.2л. Шүлгийн хэлбэрийг дуурайж зохион бичих | 5.2.к Адил төстэй шинжийг харьцуулан утгыг далдлан оньсого зохион бичих |
| | 1.2.е. Өөрийгөө 4-5 өгүүлбэрээр танилцуулж бичих | 2.2.л.Зааврын дагуу гэр бүлээ танилцуулж бичих | 3.2к.Өгсөн бүтцийн дагуу уншсан номоо тэмдэглэн бичих | 4.1м. Уншсан номыг танилцуулж бичихдээ сэтгэгдэл, мэдрэмжээ илэрхийлэх | 5.2.л.Баримт, зураг, график хэрэглэн баталгаа, нотолгоотой санаагаа илэрхийлж бичих " |
| | | 3.2л. Уншсан зохиолын талаар сэтгэгдлээ илэрхийлэн бичих | | 5.2м. Өгсөн бүтцийн дагуу үлгэр зохиох | |




Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр.....цаг



- Хэн нэгэн хүнд баярын мэнд хүргэхийг мэндчилгээ гэнэ.
- Мэндчилгээ бичихдээ баярын мэнд, аз жаргал, эрүүл энх, хүсье зэрэг үгсийг ашиглан бичнэ.

1 Мэндчилгээний эхлэл, гол, төгсгөл хэсгийг уншиж, ойлгоё.



Эхлэл хэсэг:
Хэнд зориулж бичсэн байна вэ?

Гол хэсэг:
мэндчилгээ бичиж байгаагийн учир

Төгсгөл хэсэг:
Бичсэн хүний нэр, он сар өдөр

2 Мэндчилгээг уншаад эхлэл, гол, төгсгөл хэсэг аль нь болохыг холбоорой. Ямар үгс хэрэглэн бичсэн болохыг ажиглаарай.

Хайрт ээждээ

Төгсгөл хэсэг:
Бичсэн хүний нэр, он сар өдөр

Тандаа төрсөн өдрийн баярын мэнд хүргэж, эрүүл энх, аз жаргал хүсье.

Эхлэл хэсэг:
Хэнд зориулж бичсэн байна вэ?

Охин Намуун
2021 оны 11 сарын 15

Гол хэсэг:
мэндчилгээ бичиж байгаагийн учир



Сурагчийн нэр:

Эхэлсэн: он сар өдөрцаг



Мэндчилгээ бичихдээ:

Эхлэл хэсэгт

Хэнд зориулах

Гол хэсэгт

Мэндчилгээ бичиж байгаагийн учир

Төгсгөл хэсэгт

Мэндчилгээ бичсэн хүн, хамт олон Он, сар, өдөр

Сурагчдадаа



Ангийн багш Д.Долгор
2020.09.01

1 Зургийг ажиглаарай.



2 Асуултын дагуу ярилцаарай.

1. Хэнд зориулж бичсэн байна вэ?
2. Мэндчилгээ бичсэний учир нь юу вэ?
3. Бичсэн хүний нэр хэн бэ?
4. Хэзээ бичсэн байна вэ?
5. Хэнд, ямар үед мэндчилгээ бичиж болох вэ?

3 Асуултад хариулж бичихдээ бүтэн өгүүлбэрээр бичээрэй.

1.

2.

3.

4.



Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр



Мэндчилгээг хэн нэгэнд баяр хүргэх, сайн сайхныг ерөөх зорилготой бичдэг.

1 Загварт тохируулан мэндчилгээ бичээрэй.



Хайртай ах

Хүндийн өргөлтийн тэмцээний аварга болсонд баяр хүргэе. Дэлхийн болоорой.

Хайртай дүү

..... оны-р сарын өдөр

2 Дараах үгүүдийг ашиглан хайртай хүмүүстээ мэндчилгээ бичээрэй.

аз жаргал

эрүүл энх

ажлын амжилт

баярын мэнд

Large rounded rectangular box with horizontal dotted lines for writing a message. At the bottom, it says: оны-р сарын өдөр

3 Мэндчилгээний зургийг ажиглаад, тохирсон мэндчилгээ бичээрэй.



Хэнд

Three horizontal dotted lines for writing a message.

Хэнээс

..... оны-р сарын өдөр



Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөрцаг

Болсон явдлыг ойлгомжтой бичихдээ:



- ✓ Сэдвээ сонгоно.
- ✓ Эхээ бичнэ.
- ✓ Бичсэн эхээ сайжруулан бичнэ.

Алхмын дагуу дуурайж хийгээрэй.

1

1



Өөрт тохиолдсон болсон явдлыг санаарай.

Надад тохиолдсон хөгжилтэй явдал

2

Жагсаан бичээрэй.

- Голын усанд шумбаад
- Бөмбөг өшиглөсөн
- Хөдөө амарсан
- Ах, эгч, найзтайгаа жимс түүгээд

Хонь суудаг

2

Жагсаан бичье



3

Би хамгийн хөгжилтэйг сонголоо.


Чи бас хамгийн хөгжилтэйг сонгоорой.


4

Төсөөлөн зурья.

4

Төсөөлөн зураарай.





Бичих дарааллаа төлөвлөө.



1

- ✓ Эхлээд юу болсон бэ?
- ✓ Цааш нь яасан билээ?
- ✓ Юу болж төгссөн билээ?

2

Төсөөлөн зурснаа дараалалд оруулаарай.

- ✓
- ✓
- ✓

3

Миний ноороглон бичсэн хэсэг.

Ойлгож уншаарай.

Эхлээд юу болсон бэ?

- Бороо ороод намдсан.
- Ах намайг хонь тогтож байна уу? хараарай гэв.

Цааш нь яасан билээ?

- Би гарч харав. Хонь сууж байна гэлээ.
- Тэд намайг шоолон инээв.
- Ах хонь суудаг гэж ярьдаггүй юм. Хонь хэвтэж байна гэж хэлж өгсөн.

Юу болж төгссөн билээ?

- Би хонины тухай мэддэг болсон.

4

Чиний ноороглон бичих хэсэг

Эхлээд юу болсон бэ?

Цааш нь яасан билээ?

Юу болж төгссөн билээ?




Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр.....цаг



- Хэн нэгэн хүнд баярласан, талархсан сэтгэлээ хүндэтгэн илэрхийлэхийг талархал гэнэ. Талархалаа илэрхийлэхдээ баярлаж талархсанаа, чин сэтгэлээсээ, илэрхийлье зэрэг үгийг хэрэглэнэ.

1 Талархлын эхлэл, гол, төгсгөл хэсгийг уншиж, ойлгоё.



Эхлэл хэсэг:
Хэнд зориулж бичсэн байна вэ?

Гол хэсэг:
юунд, яагаад талархаж байгаагийн учир

Төгсгөл хэсэг:
Бичсэн хүний нэр, он сар өдөр

2 Талархлыг уншаад эхлэл, гол, төгсгөл хэсэг аль нь болохыг холбоорой. Ямар үгс хэрэглэн бичсэн болохыг ажиглаарай.

Эрхэм хүндэт тогооч эгч тандаа

Төгсгөл хэсэг:
Бичсэн хүний нэр, он сар өдөр

Хүүхдүүд бидэнд үргэлж амт чанар сайтай хоол хийж өгч, эелдэг найрсаг байдагт нь баярлаж, талархсанаа илэрхийлье.

Эхлэл хэсэг:
Хэнд зориулж бичсэн байна вэ?

2а ангийн сурагч А.Тэнүүн 2021 оны 10 сарын 15

Гол хэсэг:
юунд, яагаад талархаж байгаагийн учир



Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр цаг



Талархал бичихдээ

- ✓ Хэнд бичиж байгаа
- ✓ Талархаж байгаагийн учир
- ✓ Талархлыг бичиж байгаа хүний нэр
- ✓ Он, сар, өдөр



1 Талархлыг уншаарай.

Талархал

Шавь нартаа

Цар тахлын үед цахим хичээлээ тогтмол хийж байгаа та нартаа чин сэтгэлээсээ талархал илэрхийлье.

Ангийн бали Я.Урал

2021 оны 9 дүгээр сарын 16

2 Ойлгосноо асуултад хариулж бичээрэй.

| | |
|-------------------------------|-------------------------|
| Хэнд зориулж бичсэн байна вэ? | |
| Юунд талархаж байна вэ? | |
| Хэн бичсэн байна вэ? | |
| Хэзээ бичсэн байна вэ? | |



Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр цаг



Талархал бичихдээ

- ✓Хэнд бичиж байгаа
- ✓Талархаж байгаагийн учир
- ✓Талархлыг бичиж байгаа хүний нэр
- ✓Он, сар, өдөр



1 Талархлыг уншаад, тодруулан бичээрэй.



Хайртай/ээждээ
Намайг төрүүлсэн ээждээ зурх-
нээсээ талархал илэрхийлье.
Хүү М.Танбалт
2021 оны 9 дүгээр сарын 16

2 Дугуйланд хүргэж өгдөг өвөөдөө талархлаа бичье.



Өвөө Т.Нарисжилд
Хөгжлийн дугуйланд хүргэж өгдөг
..... тандраа илэрхийлье
Ач эхчин А. Саруул
2021 оны ... дүгээр сарын ...

Гэрийнхэндээ талархал бичиж, “Талархлын мод” бүтээгээрэй.



Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр цаг



Талархал бичихдээ

- ✓ Хэнд бичиж байгаа
- ✓ Талархаж байгаагийн учир
- ✓ Талархлыг бичиж байгаа хүний нэр
- ✓ Он, сар, өдөр



1 Нэрийг нь бичиж талархлаа илэрхийлье.



Сурагч

Анги хамт олноо төлөөлөн шатрын тэмцээнд оролцсонд талархал илэрхийлье.

Багш

2021 оны дүгээр сарын

2 Найзынхаа нэрийг бичиж, талархал бичээрэй.



Дотны найз

Дотны найз

2021 оны дүгээр сарын



Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр цаг



Талархал бичихдээ

- ✓ Хэнд бичиж байгаа
- ✓ Талархаж байгаагийн учир
- ✓ Талархлыг бичиж байгаа хүний нэр
- ✓ Он, сар, өдөр

Нөхөх үг:

Тогооч
эгчид

чин
сэтгэлээсээ

хоолоор

үйлчилсэн илэрхийлье

1 Дутуу үгийг нөхөн талархлыг гүйцээж бичээрэй.



Алттай

тогооч эгчдээ

2-а ангийн сурагчид

2021 оны ... дүгээр сарын ...

Талархал

2 Зургийг ажиглаад, талархал бичье.



Явган зорчигч

2021 оны ... дүгээр сарын ...

Талархал



Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөрцаг



Эх зохиоходоо үйл явдлыг төсөөлөн бодно.

1 Зургийг үйл явдлын дарааллаар зөв дугаарлаарай.



2 Зургийн дарааллаар дугаарлаарай. Тодруулан бичээрэй.

- Эмээ гурил зуурав.
- Эмээ хуушуур чимхээж байна.
- Хуушуураа шарах болмоо.
- Эмээ нагад алттай хуушуур хийж өгсөн.

3 “Миний эмээ” сэдвээр 4-5 өгүүлбэртэй эх зохиоё. Тодруулан бичье.

Миний эмээ
 Миний эмээг Цэвэл гэдэг. Эмээ
 их ажилсал. Эмээгийн хийсэн
 хуушуур алттай. Би эмээдээ
 хайртай.



Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөрцаг



Эх зохиохдоо үйл явдлыг төсөөлөн бодоорой. Зураг зурж болно.

1 Зургийг дарааллыг зөв дугаарлаарай.



2 Зургийн дарааллаар үйл явдлыг бичээрэй.

1

Handwriting practice lines with a slanted blue line for the first line.

2

Handwriting practice lines with a slanted blue line for the second line.

3

Handwriting practice lines with a slanted blue line for the third line.

4

Handwriting practice lines with a slanted blue line for the fourth line.

3 “Миний өвөө” сэдвээр 4-5 өгүүлбэртэй эх зохиоё. Тодруулан бичье.

Handwriting practice with cursive text: Миний өвөө, Миний өвөөг гэдэг, их ажигласан, тарьсан ургав.



Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөрцаг

1 Зургийг ажиглаад зөв дугаарлаарай.



2 Зургийн дарааллаар үйл явдлыг бичээрэй.

1

2

3

4

Handwriting practice lines with slanted lines for tracing.

3 “Миний найз” сэдвээр 4-5 өгүүлбэртэй эх зохиож бичээрэй.

Handwriting practice lines for writing a story.



Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөрцаг



Ертөнцийн гурав нь Монгол ардын аман зохиолын нэгэн төрлийн сургаал хэллэг юм. Ертөнцийн гурав нь гурван мөрөөр бичигдэнэ.

1 Ертөнцийн гурвыг уншаарай. Бүтцийг ажиглая.

Ертөнцийн гурван баян

Хөх тэнгэр үүлсээр баян
Хөрст газар үндсээр баян
Хөлгүй далай загасаар баян

Хэдэн мөр байна вэ?

Мөрийн үгийн тоо хэд байна вэ? тоо

Ижил үгийг бичье.

баян

Мэдэж авлаа.

- ✓ Мөрийн тоо
- ✓ Мөрийн үгийн тоо
- ✓ Толгой холбох
- ✓ Ижил үг давтах

Толгой холбосон үгийг бичье.

хөх, хөрст, хөлгүй

2 Ертөнцийн гурвыг уншаарай. Даалгаврыг гүйцэтгээрэй.

Ертөнцийн гурван хөх

Уужим дэлхийн тэнгэр хөх

Унтрах галын дөл хөх

Урсах голын ус хөх

Хэдэн мөр байна вэ?

Мөрийн үгийн тоо хэд байна вэ?

Толгой холбосон үгийг бичээрэй.

Ижил үгийг бичээрэй.

Ертөнцийн гурван хөх

Миний Монголын тэнгэр нэг хөх

Мэндлэн золгох хадаг нэг хөх

Монгол хүүхдийн толбо нэг хөх

4-2 ангийн сурагч Д.Оргилдалай



Сурагчийн нэр:

Эхэлсэн: он сар өдөрцаг




Ертөнцийн гурав нь



- ✓ мөрийн тоо
- ✓ мөрийн үгийн тоо
- ✓ толгой холбон
- ✓ ижил үг давтан бичнэ.

1

Ертөнцийн гурвыг уншаарай.

Хөх тэнгэр  ээр баян
 Хөрст газар  ээр баян
 Хөлгүй далай  аар баян

1

Үгийг таамаглаарай.

Ертөнцийн гурван

Урсахдаа  нэг ямар?

Хийсэхэд  нэг ямар?

Өргөхөд  нэг ямар?

Нөхөж гүйцээгээрэй.

Ертөнцийн гурван хөнгөн


Урсахдаа ус нэг


Хийсэхэд нэг


Өргөхөд нэг

2

Асуултаар ертөнцийн гурвыг тайлбарлая. Цэгийн оронд асуултыг бичээрэй.

Яах? юу? хэд?
Урсахдаа  нэг ямар?

Яах? юу? хэд?
Хийсэхэд  нэг ямар?

..... юу?
Өргөхөд  нэг ямар?

Ямар? юуны? юу? ямар?
Уужим дэлхийн тэнгэр хөх

Яах? юуны?
Унтрах галын дөл хөх


Яах? юу?
Урсах голын ус хөх

3

Үгийг нөхөж бичээрэй.

Ертөнцийн гурван ариун

Нөхөх үг: Хайчилж наагаарай.



Дууссан:онсарөдөрцаг

Өөрийн үнэлгээ:

1 2 3

Ургаж

Урсаж

хүж

ус



Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөрцаг

Ертөнцийн гурав дуурайн зохиоходоо

- ✓ мөрийн тоо
- ✓ мөрийн үгийн тоо
- ✓ толгой холбон
- ✓ ижил үг давтан бичнэ.



1

Ертөнцийн гурав бүтээгээрэй.



.....

.....

.....

баян

доод

дээд

дунд

2 Цэвэр сайхан бичээрэй.




3 Ертөнцийн гурав дуурайн зохион бичье.

Ертөнцийн гурван эрдэнэ



4 Ертөнцийн гурав дуурайн зохион бичээрэй.

Ертөнцийн гурван чухал





Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр цаг


1 Дараах бүдүүвчийг ашиглан, өөрийн танилцуулгыг хийгээрэй.

| | | |
|------------------------|---------------------------------|--|
| МИЙТУХАЙ | МИЙНЭР [] | |
| БИМОНГОЛХУН | МИЙТЭЖЭЭМӨЛАМЫТАН [] | МИЙСОНРХДГ ЗҮЙЛ(ХОББИ) [] |
| | МИЙДРТАЙКНӨ | |
| МИЙГЭР | МИЙГЭРБҮЛГҮН | |
| | МИЙДРТАЙӨНӨ | |

2 Танилцуулгыг уншаад, цэгийн оронд тохирох нэрийг сонгон бичээрэй.
- Товч анкет - Өөрийн танилцуулга

| | |
|--|---|
| <p>.....</p> <p>Овог нэр: Төрсөн он сар өдөр: Регистрийн дугаар: Нас: ... Хүйс: Ам бүл: Төрсөн газар: Сурдаг сургууль: Гэрийн хаяг: Холбоо барих:</p> | <p>.....</p> <p>Миний нэрийг Сайнбаяр гэдэг. Би 2-р ангид сурдаг. Манайх ам бүл 4. Аав, ээж, ахын хамт амьдардаг. Миний хобби бол хөл бөмбөг. Байрны хажуу талбай дээр найзуудтайгаа хөл бөмбөг тоглодог. Том болоод тэмцээнд орохыг мөрөөддөг. Би бас шатар тоглож сурч байгаа. Өвөө надад зааж өгсөн юм. Зун болгон хөдөө явж, өвөө эмээдээ хурга ишиг хариулж өгдөг.</p> |
|--|---|

3 Анкет танилцуулга хоёрын ялгаа юу вэ? Дугуй тус бүрт А, Т үсгээр аль нь болохыг тэмдэглээрэй.



Дууссан:онсарөдөр цаг

Өөрийн үнэлгээ: (1) (2) (3)



Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр цаг

- 1 Сурагч Учралын гэр бүлийн танилцуулгыг уншаарай. Доорх бүтцийг гэр бүлийн танилцуулгаас олж дугаарлаарай.



Миний гэр бүл

1 Өөрийнхөө тухай Дараа нь гэр бүлийн гишүүд болон гэр чинь хаана байдаг тухай

1 Намайг Учрал гэдэг. Би 7 настай. Би өвөө, аав, ээж, эгчтэйгээ тавуулаа амьдардаг. Манай гэр Төв аймгийн төвд байдаг.

2 Гэр бүлийн гишүүн бүрийн тухай

Аавыг маань Батсүх гэдэг. 38 настай. Миний аав жолооч. Аав өдөржин том тэрэг бариад юм зөөдөг. Ээжийг маань Энхцэцэг гэдэг. 36 настай.

3 Гэр бүлийн гишүүд гэр орны ажилд юу хийж, яаж оролцдог тухай

Миний ээж сувилагч. Олон хүнд тариа хийж эдгээдэг. Өвөө маань бидэнтэй хамт амьдардаг.

4 Гэр бүлийнтэйгээ юу хамт хийдэг, хамт хаагуур явдаг тухай

Намайг өдөр бүр сургуулиас авдаг. Өвөө надад өөрийнхөө бас аавын бага насны тухай инээдтэй зүйл ярьж өгдөг. Миний эгч 7 дугаар ангид сурдаг. Надад бүжиг зааж өгдөг.

5 Гэр бүлийнхэндээ хэлэх сэтгэлийн үг

Бид гэр бүлээрээ хөдөө их явдаг. Би гэрийнхэндээ маш их хайртай



- 2 Сурагч Сайнбаярын гэр бүлийн танилцуулгын бүтцийг дээрх адил дугаарлаарай. Мөн хоосон нүдэнд өөр юуны тухай бичмээр байгаа тухай нэмж бичээрэй.

Миний нэрийг Сайнбаяр гэдэг. Би 2-р ангид сурдаг. Манайх ам бүл 4. Бид Баянзүрх дүүрэгт амьдардаг.

Миний аавыг Энхбат гэдэг. Аав маань талхны үйлдвэрт ажилладаг. Ээжийг маань Итгэл гэдэг. Ээж маань багш. Дүү 3 настай, цэцэрлэгт явдаг.

Аав өглөө, орой ээлжээр ажилдаа явдаг. Эрт ирвэл хоолоо хийж, дүүг авдаг. Орой ажилтай үед нь би дүүгээ авдаг.

Ээж багш болохоор надад гоё гоё ном авчирч өгдөг. Аав түүнээс нь дүү бид хоёрт уншиж өгдөг юм.

Би том болоод, аав ээж, дүү гуравтаа зөндөө их тус хүргэнэ. Тийм болохоор би их зүйл сурна.



Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөрцаг

Өөрийн гэр бүлийн хүмүүсийн сонирхол, хүсэл мөрөөдлийг судалъя.



1. Хүн бүрийн нэр
2. Хийдэг ажил, сургууль, цэцэрлэг
3. Сонирхдог зүйл
4. Мөрөөдөл, мөрөөдөлдөө хүрсэн тухай


Дарааллын дагуу бичээрэй

1

Наах хэсэг

1. Аавыг Даваахүү гэдэг.
2. Уурхайд жолооч ажилтай.
3. Шатар тоглох дуртай.
4. Сайхан гэр бүлтэй болсон.

Гэр бүлийн зураг



2

Зураг наах

Наах хэсэг

1. Миний нэр Хүслэн.
2. 4-р ангийн сурагч.
3. Зураг зурах дуртай.
4. "Миний мөрөөдөл" зургийн үзэсгэлэн гаргана.

Гэр бүл

Зураг наах

3

Наах хэсэг

1. Ээжийн минь нэр Сарнай.
2. Өрхийн эмнэлэгт сувилагч ажилтай.
3. Юм нэхэх дуртай.
4. Хөөрхөн гүнж, ханхүүтэй болох хүсэл нь биелэсэн.

амжилт

Жижиг хуудас сонгох

Наах хэсэгт наана.

Зураг оруулах

1. Хүний нэр

2. Ажил хөдөлмөр, сургууль

3. Сонирхдог зүйл

4. Мөрөөдөл

4

Наах хэсэг

1. Хөөрхөн дүү минь Чингүүн.
2. Тэр 4 настай, цэцэрлэгт явна.
3. Тоботоор тоглох дуртай.
4. Оддын нисгэгч болно гэж ярьдаг.

Дууссан:онсарөдөрцаг

Өөрийн үнэлгээ: ① ② ③ ④



Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөрцаг

1 Хүслэнгийн гэр бүлийн танилцуулгыг уншъя.

Миний гэр бүл

Миний нэрийг Хүслэн гэдэг. Манайх ам бүл дөрвүүлээ. Аавыг Даваахүү, ээжийг Сарнай, хөөрхөн дүүг минь Чингүүн гэдэг. Би ааваасаа шатар тоглохыг сурсан. Ээж хүсэл минь биелэсэн гэж ярьдаг. Дүү, бид хоёрын мөрөөдөл биелэнэ гэдэгт би итгэдэг.

- ✓ Хүний нэрийг томоор бичсэнийг ажиглаарай.
- ✓ ыг, ийг ямар үгэнд залгаж бичсэн байна вэ?

2 Өмнө хийсэн зурган танилцуулгаа ашиглаарай.
Дараах асуултын дагуу бичээрэй.

- ✓ Чамайг хэн гэдэг вэ?
- ✓ Ам бүл хэдүүлээ амьдардаг вэ?
- ✓ Гэр бүлийн гишүүдийн нэр, ажил, сургууль, сонирхол, мөрөөдлийг бичээрэй.

Миний гэр бүл

✓ Гэрийнхэндээ уншиж өгөөрэй. Алдаатай үг байвал дэвтэртээ засаж бичээрэй.